U.S. DEPARTMENT of STATE

TRAVEL.STATE.GOV BUREAU OF CONSULAR AFFAIRS

2015 ОНЫ ОЛОН ҮНДЭСТНИЙ ЦАГААЧЛАЛЫН ВИЗНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗААВАРЧИЛГАА

Хөтөлбөрийн агуулга

Конгрессоос баталсан Олон үндэстний цагаачлалын визний хөтөлбөрийг Төрийн департамент жил бүр зохион байгуулдаг. Цагаачлал ба харьяаллын тухай хуулийн (ЦХТХ) 203 (с) хэсэгт заасан нөхцлийн дагуу “олон үндэстний цагаачид” хэмээх цагаачлалын ангилал нь Америкийн Нэгдсэн Улсад цагаачилсан иргэдийн тоогоороо бага улсын иргэдэд зориулагдсан юм. 2015 оны санхүүгийн жилд 50,000 олон үндэстний виз (DV) олгохоор боллоо. Энэхүү хөтөлбөрт бүртгүүлэхэд ямар нэг төлбөр төлөхгүй.

Сугалаанд хожсон хүмүүс нь олон үндэстний виз авах энгийн боловч нарийн шалгуурыг хангасан байх шаардлагатай. Энэ сугалаа компьютерээр, санамсаргүй сугалах байдлаар хожигчийг шалгаруулдаг. Визийг газарзүйн зургаан бүсэд хуваарилдаг бөгөөд бүс бүрийн доторх аливаа улс тухайн жилийн олон үндэстний визийн долоон хувиас илүүг авч болохгүй.

DV-2015-ийн хувьд дараах улс орнуудын уугуул* иргэд өргөдөл гаргах эрхгүй. Учир нь эдгээр улс орнуудаас өмнөх таван жилийн хугацаанд АНУ руу 50,000-аас олон иргэд цагаачилсан байна. Үүнд:

БАНГЛАДЕШ, БРАЗИЛ, КАНАД, ХЯТАД (эх газрын), КОЛУМБИ, БҮГД НАЙРАМДАХ ДОМИНИКАН УЛС, ЭКВАДОР, ЭЛЬ САЛЬВАДОР, ГАИТИ, ЭНЭТХЭГ, ЯМАЙКА, МЕКСИК, НИГЕР, ПАКИСТАН, ФИЛИППИН, ПЕРУ, ӨМНӨД СОЛОНГОС, ИХ БРИТАНИ (Умард Ирландыг оруулахгүй) ба түүний хараат нутаг дэвсгэрүүд мөн ВЬЕТНАМ.

Хонг Конгийн Тусгай захиргааны бүс, Макаогийн Тусгай захиргааны бүс, Тайваньд төрсөн иргэд оролцох эрхтэй.

Энэ жилд гарсан өөрчлөлт: DV-2015-т Нигер улсын уугуул иргэд оролцох боломжгүй боллоо.

Сугалаанд оролцох эрх

Тавигдах шалгуур #1: Жагсаалтад орсон аль нэг улс оронд төрсөн иргэд сугалаанд оролцох эрхтэй.

Жагсаалтанд орсон улсад төрөөгүй хүмүүсийн хувьд хөтөлбөрт оролцох өөр хоёр арга бий.

- Таны эхнэр/нөхөр тань хөтөлбөрт оролцох эрхтэй улс оронд төрсөн үү? Хэрэв тийм бол та эхнэр/нөхрийн хамт хөтөлбөрт оролцож, хоёуланд тань виз олгогдоод, АНУ руу зэрэг орох боломжтой.
- Та хөтөлбөрт оролцох эрхгүй улс оронд төрсөн бөгөөд таны эцэг эх ч тэнд төрөөгүй, таныг төрөх үед тэндхийн оршин суугч биш байсан уу? Хэрэв тийм бол эцэг эхийн тань аль нэг нь DV-2015 хөтөлбөрт оролцох эрхтэй улс оронд төрсөн байвал энэхүү улс орны нэр дээр хөтөлбөрт оролцож болно. Энэ талаархи нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Тавигдах шалгуур #2: DV хөтөлбөрийн дагуух боловсрол ба ажлын туршлагын шалгуурыг хангасан байх ёстой. Үүний тулд:

- Ахлах сургуулийн боловсрол буюу түүнтэй адилтгах боловсролтой байх, тухайлбал бага болон дунд боловсролын 12 жилийн сургалтыг амжилттай дүүргэсэн байх;

  ЭСВЭЛ

- Өнгөрсөн таван жилийн хугацаанд дор хаяж хоёр жилийн сургалт буюу туршлага шаардах мэргэжлээр хоёр жил ажилласан туршлагатай байх ёстой. АНУ-ын Хөдөлмөрийн департаментийн O*Net OnLine мэдээллийн сангаас шаардлага хангасан ажлын жагсаалтыг харж болно.

Үндсэн DV хожигчийн шалгуур хангах ажлын талаархи нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Хэрэв та дээрхи 2 шалгуурыг хангаж чадахгүй байгаа бол DV сургалаанд оролцож болохгүй.

DV сугалааны бүртгэлийн хугацаа

DV 2015 Олон үндэстний визний сугалаанд 2013 оны 10 сарын 1-ны Мягмар гаригийн АНУ-ын Зүүн эргийн (Eastern Daylight Time) (GMT-4) үдийн 12.00 цагаас 2013 оны 11 сарын 2-ны Бямба гаригийн АНУ-ын Зүүн эргийн (EDT) (GMT-4) үдийн 12.00 цаг хүртэл электрон хэлбэрээр www.dvlottery.state.gov вэбсайтаар бүртгүүлэх ёстой. Бүртгэлийн хугацааны сүүлийн долоо хоног хүртэл хүлээх хэрэггүй учир нь хэт их ачааллаас болж вэбсайтад саатал үүсч болзошгүй юм. Хуулийн дагуу тухайн жилийн сугалаанд нэг хүний нэр дээр зөвхөн нэг бүртгэл хийх боломжтой. Сугалаанд давхар бүртгүүлсэн хүмүүсийг системээр хялбархан илрүүлдэг. **Хэрэв та нэгээс олон удаа бүртгүүлбэл таны бүртгэлийг сугалаанд оруулалгүй хасна.**

DV-2015 Электрон бүртгэлийн талаарх мэдээлэл

Та **www.dvlottery.state.gov** хаягаар орж Олон үндэстний визний DS 5501 электрон бүртгэлийн маягтыг (E-DV бүртгэл) бөглөж оруулах ёстой. Уг маягтыг бүрэн бөглөөгүй тохиолдолд таны бүртгүүлэлт амжилтгүй болно. DV хөтөлбөрт бүртгүүлэхэд ямар нэг төлбөр байдаггүй.

Та “Визний зөвлөгөө”, “Визний зуучлагч” гэх мэт таны өмнөөс бүртгэлийн маягтыг бөглөж өгөх санал тавьсан аливаа зуучлагчаар биш аль болох өөрөө бүртгүүлэхийг зөвлөж байна. Хэрэв та хэн нэгнээс туслалцаа авч бүртгүүлэхээр бол бүртгүүлж байх явцад дэргэд нь байж бүртгэлийг баталгаажуулсан хуудас болон бүртгэлийн дугаараа өөртөө хадгалж авч үлдэх хэрэгтэй. Бүртгэлийн баталгаажуулсан хуудас болон бүртгэлийн дугаарыг авч үлдэх нь маш чухал юм. Учир нь дараа нь энэ мэдээлэлгүйгээр вэбсайтруу орж сугалаанд шалгарсан эсэхээ мэдэх боломжгүй. Хэн нэгэнд өөрийн бүртгэлийн мэдээллийг өгөхөөс болгоомжлох хэрэгтэй. Энэ талаархи нэмэлт нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Бүртгэл амжилттай болсон тохиолдолд таны нэр болон бүртгэлийн дугаартай баталгаажуулсан хуудас дэлгэц дээр гарч ирнэ. Та өөрийн интернет программын хэвлэх функцийг ашиглан энэхүү хуудсыг хэвлэж гаргаад бүртгэлийн дугаараа хадгалах хэрэгтэй. 2014 оны 5 сарын 1-ээс эхлэн www.dvlottery.state.gov вэб хуудасны Entrant Status Check руу орж өөрийн бүртгэлийн дугаар хувийн мэдээллээ оруулж сугалааныхаа явцыг шалгах боломжтой. Вэб хуудсан дээрх ENTRANT STATUS CHECK функц л таны DV - 2015 сугалаанд шалгарснаа мэдэх цорын ганц арга юм. Эндээс та цаашдаа хэрхэн өргөдлөө үргэлжлүүлэх, цагаачлалын визэнд орох хуваарь зэрэг зааварчилгааануудыг авна. Сугалааны процессын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

E-DV бүртгэлийн маягтанд дараах мэдээллийг оруулах ёстой:

1. БҮТЭН НЭР - Овог, нэр. Паспорт дээр бичигдсэн байдлаар оруулна.

2. ТӨРСӨН ОГНОО - Өдөр, сар, он

3. ХҮЙС – Эр/Эм

4. ТӨРСӨН ХОТ

5. ТӨРСӨН УЛС – Улс орны нэр нь таны төрсөн улсын одоогийн нэр байх ёстой.

6. DV ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ ЭРХТЭЙ УЛС – Тус хөтөлбөрт оролцох эрхэй орон нь таны төрсөн орон байх ёстой. Харин одоо амьдарч байгаа газартай тань холбоогүй. Хэрэв та DV хөтөлбөрт оролцох эрхгүй улс оронд төрсөн бол, хөтөлбөрт оролцож болох өөр хувилбар байгаа эсэхийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

7. БҮРТГЭЛИЙН ЗУРАГ – Та өөрийн зургаас гадна эхнэр/нөхөр мөн бүртгүүлсэн бүх хүүхдийнхээ сүүлийн үед авхуулсан зургийг оруулах ёстойг анхаарна уу. Дижитал зургийн үзүүлэлтийн талаарх мэдээллийг үзнэ үү. Хэрэв таны эхнэр/нөхөр эсвэл хүүхэд тань АНУ-н иргэн эсвэл Хууль ёсны байнгын оршин суугч бол зураг оруулах шаардлагагүй.

Хамтдаа авхуулсан зургыг хүлээж авахгүй бөгөөд хүн тус бүрийн цээж зураг оруулах шаардлагатай. Хэрэв таны оруулсан зураг сүүлийн үед авхуулсан зураг биш, эсвэл техникийн шаардлага хангахгүй тохиолдолд таны бүртгэлийг хүчингүй болгох эсвэл визийг цуцлах болно. Дэлгэрэнгүй мэдээллийг Дижитал зургийн үзүүлэлтээс харна уу.

8. ШУУДАНГИЙН ХАЯГ – Хүлээн авагчийн нэр,
Хаягийн мөр 1,
Хаягийн мөр 2,
Хот
Дүүрэг/аймаг/,
Шуудангийн код/Зип код,
Улс.

9. ОДОО АМЬДАРЧ БУЙ УЛС.

10. УТАСНЫ ДУГААР (заавал бөглөх шаардлагагүй)

11. И-МЭЙЛ ХАЯГ - Та өөрийн байнга хэрэглэдэг и-мэйл хаягаа оруулах хэрэгтэй. Та сонгогдсон тохиолдолд Entrant Status Check-ээр орж шалгарснаа мэдээд мэдэгдэлд нь хариу өгсний дараа энэ хаягаар тань Төрийн департаментаас Entrant Status Check-рүү орж визэнд орох цаг өдрөө харах зааварчилгааг и-мэйлээр ирүүлнэ. Төрийн департаментаас таныг сугалаанд шалгарсан гэдгийг ХЭЗЭЭ ч и-мэйлээр эхэлж мэдэгдэхгүй. Сугалааны процессын талаархи нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

12. ӨНӨӨДРИЙН БАЙДЛААР ТАНЫ ЭЗЭМШСЭН БОЛОВСРОЛЫН ДЭЭД ТҮВШИН – Таны эзэмшсэн боловсролын хамгийн дээд түвшинг илтгэж байгаа нэг хариултыг тэмдэглэх ёстой: (1) Бага сургууль төгссөн, (2) Ахлах сургуулийг гэрчилгээгүй төгссөн, (3) Ахлах сургуулийг гэрчилгээтэй төгссөн, (4) Мэргэжлийн сургууль төгссөн, (5) Их сургуулийн зарим курсыг дүүргэсэн, (6) Их сургуулийг зэрэгтэй төгссөн, (7) Их сургуулийн дараах түвшний сургалт дүүргэсэн, (8) Магистрын зэрэгтэй, (9) Докторын түвшний зарим курс дүүргэсэн, (10) Докторын зэрэгтэй. Энэ талаархи нэмэлт мэдээллийг Түгээмэл асуулт дотроос үзнэ үү.

13. ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ - Гэрлээгүй, гэрлэсэн, гэрлэлт цуцлуулсан, бэлэвсэн, эсвэл тусдаа амьдардаг. Та эхнэр/нөхрийнхөө овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, төрсөн хот, улсыг техникийн шаардлага хангасан цээж зургийн хамт оруулах хэрэгтэй.

Эхнэр/нөхрөө оруулаагүй тохиолдолд таны бүртгэл хүчингүй болох мөн визний ярилцлага авах үед бусад гэр бүлийн гишүүдэд виз өгөхөөс татгалзана. Та виз мэдүүлэхээс өмнө гэр бүлээ цуцлуулах бодолтой байгаа ч эхнэр/нөхрөө заавал оруулах ёстой. Хэрэв таны эхнэр/нөхөр тань АНУ-н иргэн эсвэл Хууль ёсны байнгын оршин суугч бол олон үндэстний цагаачлалын виз авах шаардалагагүй багөөд та бүртгэлийн хуудсан дээрээ оруулсан тохиолдолд асуудал болохгүй. Гэр бүлийн гишүүдийн талаархи нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

14. ХҮҮХДИЙН ТОО - Бүртгэлдээ бүх хүүхдийнхээ овог нэр, төрсөн он сар өдөр, төрсөн газар зэргийг ЗААВАЛ оруулах ёстой. Үүнд таны гэрлээгүй бөгөөд 21 нас хүрээгүй бүх төрсөн хүүхдүүд, хууль ёсоор үрчилж авсан болон дагавар хүүхдүүд орно. Таны хүүхдүүд тантай хамт амьдардаггүй, тантай хамт цагаачлахгүй байсан ч гэсэн бүгдийг нь оруулах ёстой. Хүүхэд тус бүрийн зургийг тусд нь оруулах бөгөөд зураг бүр техникийн шаардлага хангасан байх ёстой.

Гэрлэсэн хүүхдүүд болон 21-ээс дээш настай хүүхдүүд таны бүртгэлд орох ёсгүй. Гэхдээ энэхүү насны хязгаараас давсан хүүхдүүдийг тодорхой тохиолдлуудад АНУ-ын хууль тогтоомжоор хамгаалдаг. Гэрлээгүй хүүхэд тань 21 нас хүрэхээс өмнө та DV хөтөлбөрт хамрагдаад тухайн хүүхэд виз олгогдохоос өмнө 21 нас хүрсэн бол тухайн хүүхдийг Хүүхдийн статусыг хамгаалах хуулийн дагуу 21 нас хүрээгүй гэж авч үзнэ.

АНУ-ын иргэн эсвэл хууль ёсны байнгын оршин суугч хүүхдэд DV виз олгогдохгүй тул тэднийг оруулах шаардлагагүй бөгөөд бүртгэлдээ оруулсан тохиолдолд ямар нэг асуудал үүсэхгүй. Та бүртгэлдээ оруулах ёстой бүх хүүхдээ оруулаагүй тохиолдолд таны бүртгэл хүчингүй болох мөн визний мэдүүлгийн үед гэр бүлийн гишүүдэд бүгдэд нь виз өгөхөөс татгалзана. Гэр бүлийн гишүүдийн талаархи нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

DV-2015 хөтөлбөрийн электрон бүртгэлийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Хожлыг тохиргоо

Бүс нутаг, улс бүрт хувиарлагдсан боломжит визний шалгуур хангасан бүртгэлээс компьютер ашиглан санамсаргүй байдлаар сугалааг явуулна. DV-2015 сугалаанд оролцогсод бүртгэлийн баталгаажуулсан дугаараа ашиглан E-DV вэб хуудасны Entrant Status Check рүү орж өөрсдийнхөө сонгогдсон эсэхийг харах шаардлагатай. 2014 оны 5 сарын 1-нээс эхлэн 2016 оны 6 сарын 30-ныг дуустал www.dvlottery.state.gov вэб хуудсаар Entrant Status Check рүү орж шалгаж болно.

Шалгарсан хүмүүс визний төлбөр зэрэг АНУ-д цагаачлахтай холбоотой бусад зөвлөмж бүхий мэдээлэл бүхий хуудастай танилцана. Entrant Status Check нь таны 2015 оны сугалаанд шалгарсныг мэдээлэх цорын ганц зам юм. Төрийн департамент сугалаанд хожсон тухай мэдэгдлийг шуудангаар явуулахгүй. Сугалаанд шалгараагүй хүмүүст энэ талаар нь мэдэгдсэн и-мэйл мөн явуулахгүй. Шалгараагүй хүмүүс энэ тухайгаа зөвхөн Entrant Status Check-ээр дамжуулан мэдэх болно. АНУ-ын элчин сайдын яам, консулын газрууд сонгогдсон хүмүүсийн нэрсийн жагсаалтыг өгөх боломжгүй. Сугалаанд шалгарсан эсэхээ бусдад найдаж шалгуулахгүйгээр өөрийн биеэр Entrant Status Check рүү орж шалгахыг таньд зөвлөж байна.

Та сугалаанд хожсоны дараа АНУ-д цагаачлах Олон үндэстний виз авахын тулд АНУ-ын хуулийн дагуу тавьдаг бүх шалгуурыг хангасан байх ёстой. Эдгээр шалгуур нь энд жагсаасан зарим үндэстний

төдийгүй терроризмийг дэмждэг гэх улс орны оролцогчдын шалгаруулалтын цаг хугацаа болон шалгах түвшинг харьцангуй нэмэгдүүлж болно.

Сугалаанд хожсон хүмүүс болон тэдний эрх бүхий гэр бүлийн гишүүдэд олон үндэстний виз олгох ажлыг 2015 оны 9 сарын 30-ны 24:00 цаг гэхэд дуусан байх ёстой. Энэ өдрөөс хойш ямар ч нөхцөлд олон үндэстний виз олгохгүй, өөрчлөлт хийхгүй бөгөөд гэр бүлийн гишүүд нь хожигчийн хойноос АНУ руу цагаачлах олон үндэстний виз авах боломжгүй болно. DV хөтөлбөрийн электрон бүртгэлийн талаархи нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Дижитал зураг оруулах заавар

Та дараах бүтцийн болон техникийн үзүүлэлтэд нийцсэн зураг авахуулж эсвэл зураг скайнердаж оруулж болно. Оролцогчид өөрсдийн зургийг E-DV вэб хуудсанд буй линкээр орж фото зургийн чанарыг шалгах боломжтой. Фото зургийн чанарыг шалгах энэ линк нь шаардлага хангасан болон шаардлага хангаагүй фото зургийн жишээг харуулахаас гадна зурагт тавигдах шаардлагын талаарх нэмэлт техникийн зөвлөгөөг хамруулсан.

Фото зураг нь 24 битийн өнгөний нягтралтай өнгөт зураг байх шаардлагатай**.** Хэрэв та скайнер ашиглаж байгаа бол тохиргоог нь True Color буюу 24 битийн өнгөний нягтралтай горим дээр тааруулах ёстой. Скайнердахад тавьдаг нэмэлт шаардлагыг доор дурдав.

Бүтцийн үзүүлэлт:

- **Толгойн байрлал**
  о Камер руу эгц харсан байх
  о Толгой дээш, доош, хажуу тийшээ далийгаагүй байх
  о Толгой (үсийг оруулан толгойн оройноос эрүүний үзүүр хүртэл) нийт зургийн талбайн 50-69 хувийг эзэлсэн байх. Нүдний байршил (нүүрний доод хэсгээс нүд хүртэл) нүүрний хэмжээний 56-69 хувийг эзэлсэн байх ёстой.
- **Джижтал зургийн толгойн хэмжээг харуулсан загвар**



Вэб хуудсан дээрээс гэрэл зургийн шаардлагын талаар харна уу.

- **Арын фон**
  о Саармаг, гэгээтэй өнгийн фонны өмнө байх
- **Фокус**
  о Гэрэл зургийн фокусыг тааруулсан байх
- **Чимэглэлийн зүйлс**
  о Нарны шил буюу нүүр халхалсан өөр зүйл зүүсэн буюу өмссөн байж болохгүй
- **Толгойн өмсгөл, малгай**
  о Толгойн өмсгөл, малгай нь тухайн хүний шашин шүтлэгтэй холбоотой бол хүлээн авна. Гэхдээ энэ өмсгөл, малгай нь тухайн хүний нүүрний аль ч хэсгийг халхалсан байж болохгүй. Шашны бус толгойн өмсгөл өмссөн хүмүүсийн гэрэл зургийг хүлээн авахгүй. Цэргийн албан

хаагчид, агаарын тээврийн албан хаагчид болон бусад дүрэмт хувцасны малгайтай авахуулсан гэрэл зургийг хүлээн авахгүй.

Техникийн үзүүлэлтүүд

- **Шинэ дижитал зураг авахуулах.** Шинэ дижитал зураг авахуулсан тохиолдолд дараах үзүүлэлтүүдийг хангах ёстой:
  о Зургийн файлын формат: Зураг нь Joint Photographic Experts Group (JPEG) форматтай байх
  о Зургийн файлын хэмжээ: Зургийн файлын дээд хэмжээ хоёр зуун дөчин (240KB) килобайт байх
  о Зургийн нарийвчлал: Өндрөөшөө 600 цэг буюу пиксел, өргөөшөө 600 цэг буюу пиксел. Зургийн пикселийн хэмжээ нь өндөр өргөн ижил квадрат хэмжээтэй байх ёстой.
  о Зургийн өнгөний нягтрал: 24 битийн нягтралтай байх. 24 битийн хар цагаан болон 8 битийн нягталтай зургийг хүлээн авахгүй.
- **Гэрэл зургийг скайнердаж дижитал зураг болгох.** Гэрэл зургийг скайнердахаас өмнө тухайн гэрэл зураг нь дээрх үзүүлэлтийг хангасан эсэхийг шалгах ёстой. Хэрэв зураг өнгөний нягтрал болон бүтцийн үзүүлэлтийг хангаж байвал тухайн зургийг дараах үзүүлэлтийн дагуу скайнердана.
  о Скайнерийн нарийвчлал: Доод тал нь 300 цэг/инчийн нарийвчлалтай скайнердсан байх.
  о Зургийн файлын формат: Зураг нь Joint Photographic Experts Group (JPEG) форматтай байх.
  о Зургийн файлын хэмжээ: Зургийн файлын дээд хэмжээ хоёр зуун дөчин (240KB) килобайт байна.
  о Зургийн нарийвчлал: 600 пиксел х 600 пиксел.
  о Зургийн өнгөний нягтрал: 24 битийн өнгөний нягтралтай байх [Хар цагаан буюу хагас тоны, саарал зургийг хүлээн авахгүй]

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

СУГАЛААНД ОРОЛЦОХ ЭРХ

1. "УУГУУЛ" БОЛОН “НЭРЭЭР НЬ ОРОЛЦОХ” ГЭДЭГ НЬ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?

Уугуул гэдэг нь одоо оршин суугаа болон харьяалагдах улс орноос нь үл хамааран тодорхой нэг улс оронд төрсөн хүнийг хэлдэг. Цагаачлал ба харьяаллын тухай хуулийн 202(b) хэсэгт заасны дагуу цагаачлалын асуудлын хүрээнд уугуул гэдэгт төрсөн улс орноосоо өөр улс орны нэрээр оролцох эрхтэй хүнийг мөн хамруулж ойлгодог.

АНУ-руу цагаачлах нийт хүмүүсийн тоо хэмжээ нь улс орон эсвэл газар зүйн бүс нутгаас хамааран ялгаатай байх тул хүн бүр аль нэг улс орны нэрээр оролцоно. Таны нэрээр нь оролцож буй улс орны тооны хязгаар таньд хамааралтай.

2. БИ ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ ЭРХГҮЙ УЛС ОРОНД ТӨРСӨН ХЭДИЙ Ч ОРОЛЦОЖ БОЛОХ НӨХЦӨЛ БАЙДАЛ БИЙ ЮУ?

Энэ тохиолдолд хөтөлбөрт оролцож болох хоёр арга бий. Нэгдүгээрт, хэрэв таны эхнэр/нөхөр хөтөлбөрт оролцох эрхтэй улс оронд төрсөн бол та тухайн улсын нэрээр оролцох эрхтэй болно. Гэхдээ энэ тохиолдолд танай эхнэр/нөхөр мөн шаардлагад тэнцэж, DV-2 виз авсан тохиолдолд л танд DV-1 виз олгох бөгөөд та хоёр DV визээрээ АНУ руу хамт зорчих ёстой. Үүнтэй нэгэн адилаар насанд хүрээгүй хүүхэд эцэг эхийнхээ төрсөн улс орны нэрээр виз авах боломжтой.
Хоёрдугаарт, та эцэг/эхийнхээ төрсөн улс орны нэрээр хөтөлбөрт оролцохоор мэдүүлж болно. Гэхдээ таныг төрөх үед эцэг эх тань хоёулаа хөтөлбөрт оролцох эрхгүй улс орны оршин суугч биш байсан байх ёстой. Ерөнхийдөө хүмүүс аль нэг улсад түр хугацаагаар зорчиж, түр хугацаагаар суралцаж, компани буюу засгийн газрын нэрийн өмнөөс ажил хэргийн буюу мэргэжлийн шалтгаанаар байрлаж

байсан тохиолдолд тэнд төрөөгүй буюу хууль ёсоор иргэншил аваагүй бол тухайн улсын оршин суугч гэж тооцогддоггүй.

Хэрэв та төрсөн улс орноосоо өөр улс орны нэрээр хөтөлбөрт оролцож байгаа бол энэ тухай мэдээллээ E-DV электрон бүртгэлийн маягтын 6 дугаар асуултыг бөглөхдөө бичнэ үү.

Таныг хөтөлбөрт оролцох эрхтэй болгож буй улс орон болон нэрээр нь оролцож буй улс орноо буруу бичвэл (өөрөөр хэлбэл нэрээр нь оролцох боломжгүй улс бичвэл) таны бүртгэл хасагдах болно.

3. ЯАГААД ЗАРИМ УЛС ОРНЫ УУГУУЛ ИРГЭД ОЛОН ҮНДЭСТНИЙ ВИЗИЙН ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙДАГ ВЭ?

Олон үндэстний виз нь АНУ-д цагаачилсан иргэдийн тоогоороо бага улсын иргэдэд цагаачлах боломж олгох зорилготой. Хуулинд зааснаар АНУ –д цагаачилсан иргэдийн тоогоороо их улс гэдэгт өнгөрсөн таван жилийн хугацаанд Гэр бүлийн болон Хөдөлмөр эрхлэлтийн визээр нийт 50,000 иргэн нь АНУ-д цагаачилсан улс орнуудыг хэлдэг. АНУ-ын Иргэншил, цагаачлалын алба жил бүрийн олон үндэстний визийн сугалаанд оролцох эрхгүй улс орнуудыг тодорхойлохын тулд өнгөрсөн таван жилийн хугацаанд гэр бүлийн болон хөдөлмөр эрхлэлтийн визээр цагаачлагчдын тоог нэмж нийлбэрийг гаргадаг. Жил бүрийн E-DV бүртгэлийн хугацаа эхлэхээс өмнө дээрх нийлбэрийг гаргадаг тул уугуул иргэд нь оролцох эрхгүй улс орнуудын жагсаалт өмнөх жилээсээ өөрчлөгдөх магадлалтай байдаг.

4. DV-2015 ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ ЭРХТЭЙ БҮС НУТАГ БОЛОН УЛС ОРОН БҮРИЙН УУГУУЛ ИРГЭДЭД ХУВИАРЛАГДАХ DV ВИЗНИЙ ТОО ХЭД БЭ?

АНУ-ын Иргэншил, цагаачлалын алба (USCIS) нь жил бүр Цагаачлал, харьяаллын тухай хуулийн 203 (с) хэсэгт заасан томьёоллоор бүс нутгуудад хуваарилах DV визний тоон хязгаарыг боддог. USCIS дээрх тооцоог гаргасныхаа дараа бүс нутаг бүрийн визний тоон хязгаарыг зарлана. Улс орон бүрт хувиарлагдах визний тоо нь бүс нутагт тогтоосон хязгаар, улс орон бүрийн сугалаанд оролцогчдын тоо болон оролцсон хүмүүсийн хэд нь хожигч болохоос хамаарна. Улс орон бүрийн уугуул иргэдэд нийт олгогдох визний 7-с ихгүй хувь хувиарлагдана.

5. БОЛОВСРОЛ, АЖЛЫН ТУРШЛАГЫН ШАЛГУУР НЬ ЮУ ВЭ?

АНУ-ын Цагаачлалын хуульд зааснаар DV сугалаанд оролцогч бүр дор хаяж ахлах сургуулийн боловсрол буюу түүнтэй адилтгах боловсролтой эсвэл сүүлийн таван жилийн хугацаанд дор хаяж хоёр жилийн сургалт, туршлага шаардах мэргэжлээр хоёр жил ажилласан туршлагатай байх ёстой. “Ахлах сургуулийн боловсрол буюу түүнтэй адилтгах боловсрол" гэдэг нь Америкийн Нэгдсэн Улсын бага болон дунд боловсролын 12 жилийн сургалтыг амжилттай дүүргэсэнтэй дүйцэх эсвэл өөр улс оронд АНУ-ын ахлах сургуулийн боловсролтой дүйцэхүйц албан ёсны бага болон дунд боловсролын сургалтыг амжилттай дүүргэсэн байхыг хэлнэ. Энэ шаардлагыг зөвхөн албан ёсны сургалт л хангах бөгөөд дүйцүүлэх буюу шилжүүлэн тооцсон сургалт эсвэл сертификатыг /G.E.D гэх мэт/ хүлээн зөвшөөрөхгүй. Боловсрол, ажлын туршлагыг нотлох баримт бичгийг визний ярилцлагын үеэр консулын ажилтанд өгөх ёстой.

6. DV ХӨТӨЛБӨРТ ЯМАР МЭРГЭЖЛҮҮД ТЭНЦЭХ ВЭ?

Ажлын туршлага дээр суурилсан болзлыг хангах шалгуурыг тодорхойлоход АНУ-ын Хөдөлмөрийн департаментийн O*Net OnLine мэдээллийн санг ашигладаг. O*Net OnLine мэдээллийн сан ажлын туршлагыг таван "мэргэжлийн бүсэд" ангилсан. Хөдөлмөрийн департаментийн вэбсайтад олон мэргэжлийг жагсаасан байдаг ч Олон үндэстний визийн хөтөлбөрт зөвхөн тодорхой мэргэжлүүд тэнцэнэ. Ажлын туршлагаараа Олон үндэстний визийн шалгуурт тэнцэхийн тулд та өнгөрсөн таван жилийн хугацаанд Мэргэжлийн тусгай бэлтгэлийн (SVP) 7.0 буюу түүнээс дээш зэрэглэлтэй 4, 5 дугаар мэргэжлийн бүсэд багтсан мэргэжлээр хоёр жил ажилласан туршлагатай байх ёстой.

7. БИ ХЭРХЭН ХӨДӨЛМӨРИЙН ДЕПАРТАМЕНТИЙН ВЭБСАЙТААС ШАЛГУУРТ ТЭНЦЭХ МЭРГЭЖЛҮҮДИЙГ ОЛОХ ВЭ?

Таны мэргэжил шалгуурт тэнцэх эсэхийг мэдэхийн тулд **O*Net OnLine** мэдээллийн санд орж дараах зааврыг харна уу:

1. "Find Occupations" (Мэргэжил ол) гэснийг сонгоод дараа нь "Job Family" (Мэргэжлийн бүл) гэснийг сонго;
2. "Job Family" дотроос өөрийн мэргэжлийн холбоосыг сонгож "GO" товчийг дарна;
3. Тодорхой нэг мэргэжлийг сонгоно;
4. "Job Zone" (Мэргэжлийн бүс) гэснийг дарж Мэргэжлийн бүсийн дугаар, Мэргэжлийн тусгай бэлтгэл (SVP)-ийн зэрэглэлээ олж мэднэ.

Жишээлбэл: “Aerospace Engineers” (Сансрын хөлгийн инженер) гэснийг сонгоё. Мэргэжлийн бүс хэсгийн сансрын хөлгийн инженер гэсэн мэргэжлийн дор Мэргэжлийн бүс 4, Мэргэжлийн тусгай бэлтгэл 7.0<8.0 гэсэн тайлбар харагдана. Тайлбарын дагуу **с**ансрын хөлгийн инженер нь шалгуурт тэнцэж байна.

Нэмэлт мэдээллийг Diversity Visa – List of Occupations webpage хуудаснаас харна уу.

8. E-DV ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ НАСНЫ ДООД ХЯЗГААР БАЙДАГ УУ?

Тус хөтөлбөрт оролцох насны доод хязгаарыг заагаагүй боловч гол бүртгүүлэгч бүртгүүлэх үедээ ахлах сургуулийн боловсролтой буюу ажлын туршлагатай байхыг шаарддаг тул 18-аас доош насны ихэнх хүмүүс энэ шалгуурт тэнцэхгүй.

DV ХӨТӨЛБӨРИЙН ЭЛЕКТРОН БҮРТГЭЛ

9. БИ ХЭЗЭЭ ХӨТӨЛБӨРТ БҮРТГҮҮЛЖ БОЛОХ ВЭ?

DV-2015-т оролцох бүртгэл 2013 оны 10 сарын 1-ны Мягмар гаригийн АНУ-ын Зүүн эргийн (EDT) (GMT-4) үдийн 12.00 цагаас 2014 оны 11сарын 2-ны Бямба гаригийн АНУ-ын Зүүн эргийн (EST) (GMT- 4) үдийн 12.00 цагийн хооронд үргэлжилнэ. Жил бүр бүртгэлийн хугацаанд олон сая хүн хөтөлбөрт оролцдог. Бүртгэлийн хугацааг ингэж заагласнаар хожсон хүмүүс зохих хугацаанд нь мэдээлэлээ олж авах, түүнчлэн виз мэдүүлэгчид болон элчин сайдын яам, консулын газруудын аль алинд нь виз мэдүүлэхэд бэлтгэх, хянан шийдвэрлэхэд хугацаа олгож байгаа юм.

Танд бүртгэлийн хугацааны дотор аль болох эрт бүртгүүлэхийг зөвлөж байна. Бүртгэлийн хугацааны сүүлээр ачаалал ихэсдэгээс шалтгаалж системийн хурд удааширч болно. 2013 оны 11 дүгээр сарын 2-ны Бямба гаригийн АНУ- ын Зүүн эргийн (EST) үдийн 12.00 цагаас хойш ямар ч бүртгэл хүлээн авахгүй.

10. БИ ОДОО АНУ-Д БАЙГАА. БИ ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОЖ БОЛОХ УУ?

Тиймээ, бүртгүүлэгч нь АНУ буюу өөр улсад байж болно. Мөн АНУ-аас буюу гадаадаас бүртгүүлж болно.

11. БҮРТГЭЛИЙН ХУГАЦААНД БИ НЭГ Л УДАА ОРОЛЦОХ ЭРХТЭЙ ЮУ?

Тиймээ, бүртгэлийн хугацааны турш хүн бүр нэг л удаа бүртгүүлэхийг хуулиар зөвшөөрсөн. Төрийн департамент бүртгэлийн хугацааны турш олон бүртгэл оруулсан хүмүүсийг илрүүлэх боловсронгуй технологи ашигладаг. **Хэрэв та нэгээс олон удаа бүртгүүлвэл хөтөлбөрөөс хасагдана.**

12. БИ ЭХНЭР/НӨХӨРТӨЙГӨӨ ТУСДАА ОРОЛЦОЖ БОЛОХ УУ?

Тиймээ, эхнэр нөхөр хоёр хоёулаа шалгуурт тэнцэж байвал тус тусдаа бүртгүүлж оролцож болно. Аль нэг нь сонгогдсон тохиолдолд нөгөөх нь дагаж явах эрхтэй.

13. E-DV БҮРТГЭЛД БИ ГЭР БҮЛИЙНХЭЭ ЯМАР ГИШҮҮДИЙГ ОРУУЛАХ ЁСТОЙ ВЭ?

Эхнэр/нөхөр: Та өөрийн эхнэр/нөхрийг одоогоор тантай хамт амьдардаг амьдардаггүй, тантай хамт цагаачлах цагаачлахгүй байсан ч заавал оруулах ёстой. Та эхнэр/нөхрөөсөө тусгаарласан хэдий ч хууль ёсны дагуу салаагүй байгаа бол (өөрөөр хэлбэл шүүх буюу шүүхийн тогтоолоор хүлээн зөвшөөрсөн бичгээр байгуулсан гэрээ байхгүй бол) бүртгэлд оруулна. Хэрэв та хууль ёсны дагуу салсан буюу гэр бүлээ цуцлуулсан бол хуучин эхнэр/нөхрөө бичих шаардлагагүй бөгөөд оруулсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй. Мөн таны эхнэр/нөхөр нас барсан бол оруулах хэрэггүй.

Хүүхэд: Та гэрлээгүй бөгөөд 21 нас хүрээгүй бүх төрсөн хүүхдүүд, эхнэр/нөхрийнхөө хүүхдүүд (тухайн хүүхдийн эцэг/эхээс салсан байсан ч), эх орныхоо хуулийн дагуу албан ёсоор үрчилж авсан хүүхдүүдээ АНУ-ын иргэн болон хууль ёсны байнгын оршин суугч биш л бол DV хөтөлбөрт анх оролцох үедээ багтаах ёстой. Таны хүүхдүүд тантай хамт амьдрахаа больсон, таныг дагаж цагаачлахгүй байсан ч бүртгэлд оруулах хэрэгтэй. Хэрэв таны хүүхэд АНУ-н иргэн эсвэл Хууль ёсны байнгын оршин суугч бол та бүртгэлийн хуудсан дээр оруулах шаардлагагүй бөгөөд оруулсан тохиолдолд асуудал үүсэхгүй.

Сугалаанд бүртгүүлж байгаа хүний эцэг эх болон төрсөн ах эгч дүү нар бүртгүүлж байгаа хүнийг дагалдан DV виз авах боломжгүй бөгөөд бүртгэлд оруулах шаардлагагүй.

Та гэр бүлийнхээ гишүүдийг бүртгэлд оруулсан нь тэд тантай заавал хамт явах ёстой гэсэн үг биш. Тэд үлдэхээр шийдэж болно. Гэхдээ та анх сугалаанд бүртгүүлэхдээ оруулаагүй гишүүнээ визний өргөдлийн маягтан дээр оруулсан тохиолдолд таны бүртгэлийг хасаж хэнд нь ч виз олгох боломжгүй болно. Энэ нь анх бүртгүүлэх үед гэр бүлийн гишүүн гэж бүртгэгдсэн хүмүүст л хамаатай бөгөөд сүүлд нэмэгдсэн гэр бүлийн гишүүдэд хамаагүй. Таны эхнэр/нөхөр таны бүртгэлд орсон ч гэсэн тусдаа бүртгүүлж болно. Гол нь хоёр бүртгэлдээ хоёуланд нь бүртгүүлэх ёстой гэр бүлийнхээ бүх гишүүдийн тухай мэдээллийг оруулах ёстой. (Энэ талаархи нэмэлт мэдээллийг Түгээмэл асуулт №12-оос үзнэ үү).

14. БИ ЗААВАЛ ӨӨРӨӨ БҮРТГҮҮЛЭХ ЁСТОЙ ЮУ ЭСВЭЛ ХЭН НЭГ ХҮН МИНИЙ ӨМНӨӨС БҮРТГҮҮЛЖ БОЛОХ УУ?

Таньд бүртгэлээ өөрөө хийхийг зөвлөж байна. Гэхдээ өөр хүнээр бүртгүүлүүлж болно. Өөрөө шууд бүртгүүлсэн ч бай, өмгөөлөгч, таньдаг хүн, төрөл садныхаа хүнээс тусламж авсан ч бай хүн бүрийн нэр дээр нэг л бүртгэл оруулах ёстой бөгөөд бүртгэл дээрх мэдээллийн үнэн зөв, бүрэн эсэхийг бүртгүүлэгч өөрөө хариуцна гэдгийг санаж байх ёстой. Оролцогчид өөрсдийн бүртгэлийн баталгаажсан дугаарыг хадгалах ёстой бөгөөд энэ дугаарын тусламжтайгаар www.dvlottery.state.gov руу орж ENTRANT STATUS CHECK-ээр бүртгэлийнхээ явцыг өөрөө шалгана.

15. БИ ӨӨР ТӨРЛИЙН ЦАГААЧЛАЛЫН ВИЗЭНД БҮРТГҮҮЛСЭН БАЙГАА ХЭДИЙ Ч DV ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОЖ БОЛОХ УУ?

Тийм.

16. ОНЛАЙН E-DV БҮРТГЭЛ ХЭЗЭЭ ЭХЛЭХ ВЭ?

2013 оны 10 дугаар сарын 1-ны Мягтар гаригийн АНУ-ын Зүүн бүсийн өдрийн цагийн бүсийн (EDT)(GMT-4) үдийн 12.00 цагаас 2013 оны 11 дүгээр сарын 2-ны Бямба гаригийн АНУ-ын Зүүн

бүсийн стандарт цагийн бүсийн (EST) (GMT-5) үдийн 12.00 цаг хүртэл интернетээр бүртгүүлэх боломжтой.

17. E-DV БҮРТГЭЛИЙН МАЯГТЫГ MICROSOFT WORD ПРОГРАМ (БУЮУ БУСАД ТОХИРОМЖТОЙ ПРОГРАМ РУУ) ТАТАН АВЧ ХАДГАЛААД ДАРАА НЬ БӨГЛӨЖ БОЛОХ УУ?

Үгүй, та энэ маягтыг сүүлд бөглөж өгөхөөр өөр програмд хадгалах боломжгүй. E-DV бүртгэлийн маягт нь зөвхөн онлайн бөглөдөг маягт юм. Тиймээс та тус маягтыг бөглөхдөө онлайнаар мэдээллээ оруулж, илгээх шаардлагатай.

18. БҮРТГЭЛИЙН МАЯГТЫН НЭГ ХЭСГИЙГ НЬ БӨГЛӨӨД ИНТЕРНЕТЭД ХАДГАЛЖ ДАРАА НЬ ЭРГЭЖ ОРООД ГҮЙЦЭЭН БӨГЛӨЖ БОЛОХ УУ?

Үгүй. E-DV бүртгэлийн маягтыг нэгмөсөн бөглөж оруулахаар зохиосон. Та маягтыг татаж авахаас эхлээд бүртгэлийг интернетээр оруулж E-DV вэбсайт дээр хүлээн авах хүртэлх нийт хугацаа жаран (60) минут байхаар E-DV системийг бүтээсэн. Жараас илүү минут өнгөрч мөн бүртгэл электрон хэлбэрээр орж амжаагүй бол оруулсан бүх мэдээлэл хүчингүй болно. Ингэснээр бүтэн оруулсан бүртгэл нь өмнө хагас дутуу оруулсан бүртгэлийн хуулбар байна гэж ойлгогдох эрсдлээс сэргийлж байгаа юм. Маягт бөглөж эхлэхээсээ өмнө хэрэгтэй бүх мэдээллээ бэлдэж, бүрэн бэлтгэлтэй байхын тулд DV бүртгэлийн зааварчилгааг уншиж танилцана уу.

19. ХЭРЭВ НАДАД СКАЙНЕР БАЙХГҮЙ БОЛ БИ ЗУРГАА АНУ-Д БАЙДАГ ХАМААТАН РУУГАА ЯВУУЛААД СКАЙНЕРДУУЛЖ, ДИСКЭНД БУУЛГУУЛААД ТЭР ДИСКИЙГ ШУУДАНГААР АВААД БҮРТГҮҮЛЖ БОЛОХ УУ?

Тиймээ, гэрэл зураг тань энэхүү зааварчилгаан дээр байгаа гэрэл зурагт тавих шаардлагыг хангаж байгаа бөгөөд E-DV онлайн бүртгүүлэхдээ тэр зургаа электрон хэлбэрээр оруулж чадвал болно. Интернетээр бүртгүүлэхээсээ өмнө бэлэн скайнердсан гэрэл зургийн файлтай байх ёстой. Гэрэл зургаа онлайн бүртгэлээсээ тусад нь оруулж болохгүй. Та сугалаанд АНУ эсвэл бусад гадаад улсаас бүрэн электрон хэлбэрээр (гэрэл зураг, бүртгэлийг хамтад нь) бүртгүүлж болно.

20. ХЭРЭВ ОРУУЛСАН ДИЖИТАЛ ЗУРГУУД ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХГҮЙ БОЛ СИСТЕМ E-DV БҮРТГЭЛИЙН МАЯГТЫГ АВТОМАТААР ТАТГАЛЗАЖ, ИЛГЭЭГЧИД МЭДЭГДЭНЭ ГЭЖ БАЙНА. ТЭГЭХЭЭР БИ БҮРТГЭЛЭЭ ДАХИЖ ОРУУЛЖ БОЛНО ГЭСЭН ҮГ ҮҮ?

Тийм. Таны оруулсан дижил зураг (зургууд) үзүүлэлт хангахгүй тохиолдолд E-DV вэбсайт бүртгэлийг автоматаар татгалзах тул таньд бүртгэлийг хүлээн авсан тухай баталгааны мэдэгдэл ирэхгүй. Гэхдээ зураг авахаас татгалзсан тухай мэдээ ирэх хүртэл зарцуулагдах хугацаа тухайн интернетийн хурдаас хамаарах тул урьдчилан хэлэх аргагүй юм. Хэрвээ бүртгүүлэгч зургийн асуудлыг шийдвэрлээд маягтын нэг, хоёрдугаар хэсгээ жаран (60) минутын дотор дахин илгээж амжвал ямар ч асуудалгүй. Ингэж амжаагүй тохиолдолд бүртгүүлэх явцыг дахиад эхлэхээс өөр аргагүй болно. Систем гүйцэд бөглөсөн бүртгэл хүлээн авч, баталгаажсан мэдэгдэл илгээх хүртэл хэдэн ч удаа бүртгүүлэхийг оролдож болно. Баталгааны мэдэгдлийг хүлээн авсны дараа дахин нэмэлт бүртгэл хийх ёсгүй.

21. БҮРТГЭЛИЙГ ИЛГЭЭСНИЙ ДАРАА ОНЛАЙН СИСТЕМ ХҮЛЭЭН АВСНЫГ НОТЛОХ ЭЛЕКТРОН МЭДЭГДЛИЙГ ХЭР ХУРДАН ХҮЛЭЭЖ АВАХ ВЭ?

E-DV вэбсайт электрон мэдэгдлийг хадгалж авах шаардлагатай баталгаажсан дугаарын хамт тэр даруй явуулдаг. Гэхдээ энэ нь бүртгүүлэгчид хэр удаж хүрэхийг тухайн интернетийн хурд, и-мэйлийн системээс шалтгаалан урьдчилан таамаглах аргагүй. Та ‘Submit’ (Оруул) товчийг онлайн систем таны бүртгэлийг хүлээн авч таньд электрон мэдэгдэл ирэх хүртэл хэдэн ч удаа дарж болно.

Харин бүртгэлийг баталгаажуулсан хуудсыг хүлээн авсны дараа ‘Submit’ (Оруул) товчийг дахин дарж болохгүй.

ХОЖИГЧ СОНГОХ ЯВЦ

22. БИ DV СУГАЛААНД СОНГОГДСОН ЭСЭХЭЭ ХЭРХЭН МЭДЭЖ БОЛОХ ВЭ?

Та онлайнаар сугалаанд бүртгүүлэхэд гарч ирсэн бүртгэлийн дугаараа ашиглан 2014 оны 5 сарын 1-нээс 2015 оны 9 сар хүртэл E-DV-ийн www.dvlottery.state.gov вэб хуудсаар орж Entrant Status Check-ээр статусаа шалгах хэрэгтэй. Entrant Status Check нь таны сугалаанд шалгарсныг мэдээлэх цорын ганц арга бөгөөд визний өргөдлөө хэрхэн үргэлжлүүлэх, визэнд орох өдөр, цаг зэргийг тан мэдээлнэ. E-DV-ийн www.dvlottery.state.gov вэб хуудас бол DV сугалаанд оролцох болон шалгарснаа мэдэх Төрийн департаментийн цорын ганц албан ёсны хуудас юм.

Төрийн департамент таныг сугалаанд хожсон талаар ХЭЗЭЭ Ч таньтай холбоо барьж мэдээлэхгүй. (Энэ талаархи нэмэлт мэдээллийг Түгээмэл асуулт №23-аас үзнэ үү).

23. БИ СУГАЛААНД СОНГОГДООГҮЙ ГЭДГЭЭ ЯАЖ МЭДЭХ ВЭ? НАДАД МЭДЭГДЭХ ҮҮ?

Та 2014 оны 5 сарын 1-нээс 2015 оны 6 сарын 30 хүртэл E-DV-ийн www.dvlottery.state.gov вэб хуудсаар орж Entrant Status Check-ээс шалгарсан эсэхээ мэдэх боломжтой. Та баталгаажсан бүртгэлийн дугаараа дор хаяж 2015 оны 9 сарын 30 хүртэл хадгалах хэрэгтэй. (Өмнөх жилийн DV-2014 сугалааны статусыг 2013 оны 5 сарын 1-нээс 2014 оны 6 сарын 30 хүртэл шалгах боломжтой). Та сугалаанд сонгогдоогүй бол ямар ч нэмэлт зааварчилгаа хүлээн авахгүй.

24. БИ БҮРТГЭЛИЙН БАТАЛГААЖСАН ДУГААРАА ГЭЭСЭН ТОХИОЛДОЛД ЯАХ ВЭ?

Та Entrant Status Check-рүү орохын тулд таны баталгаажсан дугаар хэрэг болно. E-DV вэбсайтны Entrant Status Check дотор баталгаажсан дугаараа сэргээж авах шинэ систем бий болсон. Үүний тулд та өөрийгөө батлах хувийн мэдээллийг оруулсанаар сугалаанд бүртгүүлэхэд оруулсан имэйл хаягруу тань таны баталгаажсан дугаар илгээгдэх болно.

Та зөвхөн Entrant Status Check-н баталгаажсан дугаар сэргээх систем ашиглан өөрийн дугаараа авах боломжтой бөгөөд АНУ-ын ЭСЯам, Консулын газрууд болон Кэнтаки дахь Консулын Төв DV сугалааны статус шалгах системд орж таны баталгаажсан дугаарыг гаргаж өгөх боломжгүй юм. Мөн Төрийн департамент сугалаанд хожсон визэнд орох хүмүүсийн жагсаалтыг гаргаж өгөхгүй.

25. БИ ТӨРИЙН ДЕПАРТАМЕНТААС ИМЭЙЛ ЭСВЭЛ ШУУДАНГААР МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭЖ АВАХ УУ?

Төрийн департаментаас таньд мэдэгдэл захиа явуулахгүй. АНУ-ын Засгийн газар шалгарсан хүмүүст хэзээ ч и-мэйл явуулж байгаагүй бөгөөд DV-2015 хөтөлбөрт ч и-мэйл ашиглах төлөвлөгөө байхгүй. Та шалгарсан тохиолдолд заавал эхэлж Entrant Status Check -ийн зааварт хариу өгч таны цаашдын процесс эхэлсний дараа л и-мэйл хүлээн авна. Энэ и-мэйл нь таныг Entrant Status Check рүү орж визэнд орох өдөр, цагаа мэдэхийг зөвлөх ба тухайн визний ярилцлага хийх өдөр цагийн талаарх мэдээллийг агуулахгүй.

Та ".gov" төгсгөл бүхий хаягтай вэбсайтууд л АНУ-ын засгийн газрын албан ёсны интернэт вэбсайтууд гэдгийг анхаарна уу. Засгийн газрын бус олон вэбсайт (жишээлбэл, ".com", ".org", ".net" зэрэг төгсгөлтэй вэбсайтууд) цагаачлал болон визтэй холбоотой мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлдэг. Агуулгаас нь үл хамааран Төрийн департамент эдгээр засгийн газрын бус вэбсайтуудын аливаа мэдээлэл, материалыг баталж, санал болгож, ивээн тэтгэдэггүй.

Зарим вэбсайт өөрсдийгөө албан ёсны вэбсайт гэж олон нийт, үйлчлүүлэгчдэд итгүүлж төөрөгдүүлэхийг хичээн таныг төлбөр төлөх эсвэл хувийн мэдээллээ явуулахыг шаардах магадлалтай. Эдгээр вэбсайтууд Төрийн департаментийн вэбсайт юмуу АНУ-ын ЭСЯ/Консулын газрын вэбсайтаас үнэ төлбөргүй авч болох цагаачлалын талаарх мэдээлэл болон маягт зэргийг танд санал болгохдоо төлбөр төлөхийг шаарддаг. Үүний зэрэгцээ эдгээр вэбсайт нь таны мөнгийг шууд залилж авахын тулд DV визтэй холбогдох үйлчилгээний хөлсийг танаас нэхэж болно. Та эдгээр залилан мэхлэгчдэд мөнгөө явуулбал эргүүлж авах магадлал маш бага гэдгийг анхаарна уу. Хувийн мэдээллийг тан залилан/хулгайн гэмт хэрэгт ашиглаж болох тул эдгээр вэбсайтад хувийн мэдээллээ дамжуулахаас болгоомжлоорой.

26. DV-2015 ХӨТӨЛБӨРТ ХЭДЭН ХҮН СОНГОГДОХ ВЭ?

DV-2015 хөтөлбөрөөр нийт 50,000 DV виз өгөх боломжтой. Сонгогдсон эхний 50,000 хүнээс визний шалгуурт тэнцэхгүй хүмүүс болон визээ мэдүүлэхгүй орхих хүмүүс ч гарна. Гэхдээ энэ нь нөгөө талаар анх сонгогдсон бүх хүнд хүрэлцэхүйц тооны виз байна гэсэн үг биш.

Та E-DV вэбсайтны ENTRANT STATUS CHECK-рүү орж өөрийн шалгарсан эсэх мөн жагсаалтад өөрийнхөө хаана байгаа дараалыг харах боломжтой. DV-2015 хөтөлбөрийн визний ярилцлага 2014 оны 10 дугаар сард эхэлнэ. Үүнд зааварчилгаа мэдэгдлийн дагуу баримт бичгээ бүрдүүлж өгсөн хүмүүс оролцоно. Бүх шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж өгсөн шалгарсан хүмүүст E-DV вэбсайтны ENTRANT STATUS CHECK-ээс АНУ-ын консулын хэлтэст болох визний ярилцлага өгөх өдөр цагыг хуваарьт өдрөөс 4-6 долоо хоногийн өмнө мэдэгдэнэ.

Сар бүр визний байгаа дугаараас хамааран тухайн сард виз авахад бэлэн шалгарсан хүмүүст виз олгоно. Бүх 50,000 DV виз олгогдож дууссанаар тухайн жилийн хөтөлбөр дуусна. Энэ нь бүх виз олгогдогдсон тохиолдолд хөтөлбөр 2015 оны 9 сараас өмнө дуусах боломжтой гэсэн үг юм. Шалгарсан хүмүүс визээ авахыг хүсвэл хурдан шуурхай хөөцөлдөхөд бэлэн байх ёстой. **Компьютерээр хийдэг санамсаргүй сонголтонд шалгарснаар та автоматаар виз авах баталгаатай боллоо гэж бодож болохгүй. Сугалаанд шалгарна гэдэг нь та DV виз хүсэх эрхтэй болсон бөгөөд харин шаардлага хангавал виз авна гэсэн үг юм. Зөвхөн эхний 50,000 шалгарсан оролцогч визний шаардлага хангавал визээ авна.**

27. АМЖИЛТТАЙ БҮРТГҮҮЛСЭН ОРОЛЦОГЧДЫГ ХЭРХЭН СОНГОХ ВЭ?

Албан ёсны мэдэгдэл 2014 оны 5 сарын 1-нээс эхлэн 2015 оны 6 сарын 30-ны хооронд E-DV-ийн www.dvlottery.state.gov **вэб хуудасны Entrant Status Check дээр гарна. Төрийн департамент сугалаанд шалгарсан хүмүүст шалгарсныг нь и-мэйл эсвэл шуудангаар захидал илгээдэггүй. Хэрэв танд сугалаанд шалгарсан талаар и-мэйл эсвэл шуудангаар захидал ирвэл хууль бус гэдгийг анхааараарай. Та шалгарлаа гэхэд та өөрөө заавал эхэлж Entrant Status Check рүү орж шалгаад заасан зааварт хариу өгч таны цаашдын процесс эхэлсний дараа л Төрийн департаментаас танд Entrant Status Check рүү орж шинэ мэдээлэл шалгах талаар зөвлөсөн зааварчилгааг и-мэйлээр өгнө. Төрийн департамент хэзээ ч танд шуудангаар юм уу Western Union гэх мэт аргаар төлбөр гуйвуулах хүсэлт тавихгүй.**

Газарзүйн бүс тус бүрээс ирсэн бүх бүртгэлийг нэгбүрчлэн дугаарлана. Бүртгэлийн хугацаа дууссаны дараа компьютер газарзүйн бүс бүрээс хүлээн авсан бүх бүртгэлээс санамсаргүй байдлаар сонголт хийнэ. Бүс бүрээсээ санамсаргүй байдлаар сонгогдсон эхний бүртгэл нэгт, хоёр дахь бүртгэл хоёрт гэх мэтчилэн бүртгэгдэнэ. Хугацаанд нь амжилттай илгээсэн бүх бүртгэл бүсийнхээ хүрээнд сонгогдох магадлал нь ижил байна. Компьютер аль нэг бүртгэлийг сугалж гаргасны дараа E-DV-ийн www.dvlottery.state.gov вэб хуудасны Entrant Status Check-ээс тухайн шалгарсан оролцогч 2014 оны 5 сарын 1-нээс эхлэн шалгарсан эсэхээ мэдэх болно. Шалгарсан хүмүүс АНУ-ын ЭСЯ/Консулын газарт визэнд орох заавар автал, мөн статусаа өөрчлөх боломжтой болсон хүмүүс дотоодын АНУ-н Иргэн

болон Цагаачалалын Алба (USCIS)-ын салбарт өргөдөл гаргах хүртэл Kentucky Consular Center (KCC) асуудлыг хариуцах болно.

28. БИ ОДОО АНУ-Д БАЙГАА. ХЭРЭВ СОНГОГДВОЛ СТАТУСАА ӨӨРЧЛӨХӨӨР USCIS-Д ХАНДАЖ БОЛОХ УУ?

Тийм, тэд ЦХТХ-ийн 245 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу статусаа өөрчлөх эрхтэй бол, АНУ-д байгаа сонгогдсон хүмүүс өөрсдийн статусаа байнгын оршин суугчийн статус болгон өөрчлөхийн тулд USCIS- д хандаж болно. Та 2015 оны 9 дүгээр сарын 30-наас өмнө USCIS таны мэдүүлгийг шийдвэрлэж, АНУ-д таныг дагалдаж ирэх хүмүүсийн материалыг хянан шийдвэрлэсэн байх ёстойг анхаарна уу. Учир нь тэр өдөр таны DV-2015 хөтөлбөрт оролцох хугацаа дуусна. 2015 оны 9 дүгээр сарын 30-ны шөнө дундаас хойш ямар ч нөхцөлд DV-2015 хөтөлбөрийн виз олгохгүй.

29. ХЭРЭВ БИ СОНГОГДВОЛ, ХЭР УДААН ХУГАЦААНД DV КАТЕГОРИОР ВИЗ ХҮСЭХ ЭРХТЭЙ ВЭ?

Хэрэв та DV-2015 сугалаанд сонгогдвол зөвхөн АНУ-ын Засгийн газрын 2015 оны санхүүгийн жилийн турш буюу 2014 оны 10 дугаар сарын 1- нээс 2015 оны 9 дүгээр сарын 30 хүртэлх хугацаанд виз хүсэх эрхтэй.

Өргөдөл гаргагчид санхүүгийн жилийн эцэс гэхэд DV визээ авах буюу статусаа өөрчилсөн байх ёстой. Сонгогдсон боловч 2015 оны санхүүгийн жилд багтан визээ авч чадаагүй хүмүүсийн DV виз хүсэх эрхийг дараа он руу шилжүүлдэггүй. Мөн DV-2015 сугалаанд хожигсдын эхнэр/нөхөр буюу хүүхдүүд 2014 оны 10 дугаар сарын 1-нээс 2015 оны 9 дүгээр сарын 30 хүртэлх хугацаанд л DV виз авах боломжтой. Гадаадаас бүртгэл хийсэн хүмүүст Төрийн департаментаас ярилцлага болох өдрөөс 4-6 долоо хоногийн өмнө ярилцлагын цагийг ENTRANT STATUS CHECK –ээр дамжуулж мэдэгдэнэ.

30. E-DV-Д СОНГОГДСОН ХҮН НАС БАРВАЛ DV ВИЗНИЙ АСУУДАЛ ЮУ БОЛОХ ВЭ?

Сугалаанд сонгогдсон хүн АНУ-руу явахаас өмнө нас барвал тухайн DV бүртгэл автоматаар хүчингүй болно. Нас барсан хүний эхнэр/нөхөр, хүүхдүүд тухайн хожлоор DV виз авах эрхгүй болно.

ТӨЛБӨР

31. E-DV ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХОД ХЭДЭН ТӨГРӨГ ТӨЛӨХ ВЭ?

Одоогоор электрон сугалаанд бүртгүүлэхэд ямар ч хураамж төлөхгүй. Гэхдээ та сугалаанд сонгогдож DV визний мэдүүлэг өгөх үедээ шаардлагатай бүх визний хураамжийг тухайн АНУ-ын ЭСЯ/Консулын газрын кассанд шууд тушаах ёстой. АНУ-д оршин суугаа оролцогчид болон статусаа өөрчлүүлэхээр өргөдөл гаргасан хүмүүс төлбөрөө USCIS-д шууд төлнө. Сугалаанд шалгарсан хүмүүст E-DV www.dvlottery.state.gov вэб хуудасны Entrant Status Check-ээр DV визний талаарх өргөдлийн хураамжтай холбоотой мэдээлэл зааварчилгааг илгээдэг.

32. ХЭРЭВ БИ СОНГОГДВОЛ DV БОЛОН ЦАГААЧЛАЛЫН ВИЗНИЙ ТӨЛБӨРИЙГ ХААНА ЯАЖ ТӨЛӨХ ВЭ?

Та сугалаанд сонгогдсоны дараа www.dvlottery.state.gov вэб хуудасны Entrant Status Check-ээр дамжуулан DV визний өргөдөл мэдүүлэх зааварчилгаа авна. Та DV визний өргөдөл өгөх үедээ шаардлагатай бүх визний хураамжийг АНУ-ын ЭСЯ/Консулын газарт биечлэн тушаах ёстой. Консулын касс төлбөр хүлээн авсныг нотлох баримтыг мөнгө төлсөн даруйд тань өгнө. Хэрэв та АНУ-ын ЭСЯ/Консулын газарт цагаачлалын виз мэдүүлж байгаа бол DV визний хураамжын төлбөрийг шуудан, Western Union, эсвэл бусад хүргэлтийн үйлчилгээг ашиглан хэнд ч илгээх ёсгүй. Хэрэв та сонгогдсон бөгөөд АНУ-д оршин суудаг мөн USCIS-д өргөдөл гаргаж статусаа өөрчлүүлэх

гэж байгаа бол www.dvlottery.state.gov вэб хуудасны Entrant Status Check дотор DV визний төлбөрийг АНУ-н банк руу хэрхэн илгээх тусдаа зааварчилгаатай танилцана уу.

33. БИ СУГАЛААНД ШАЛГАРААД ВИЗЭЭ ХҮССЭН БОЛОВЧ ВИЗНИЙ ШАЛГУУР ХАНГААГҮЙ ҮНДЭСЛЭЛЭЭР ТАТГАЛЗСАН ХАРИУ АВБАЛ ВИЗНИЙ ТӨЛБӨРӨӨ ЭРГҮҮЛЭН АВЧ БОЛОХ УУ?

Үгүй. Визний төлбөр эргэн олгогдохгүй. DV виз мэдүүлэгчид виз авах бүх шалгуурыг хангах хэрэгтэй. Хэрэв тухайн виз мэдүүлэгч виз авах шалгуур хангаагүй эсвэл АНУ-ын Цагаачлалын хуулийн шалгуурт тэнцэхгүй гэж үзвэл виз олгохоос татгалзах ба визний төлбөрийг буцаан олгохгүй.

ШАЛГУУР ХАНГАХГҮЙ БАЙХ

34. DV ХҮСЭГЧИД ВИЗИЙН ШАЛГУУР ХАНГАХГҮЙ БАЙГАА ЯМАР НЭГ ҮНДЭСЛЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ҮҮ? ИЙНХҮҮ ЧӨЛӨӨЛӨГДӨХ ХҮСЭЛТ ГАРГАВАЛ ТУСГАЙЛАН АВЧ ҮЗЭХ ҮҮ?

Үгүй. Цагаачлал, харьяаллын тухай хуульд заасан цагаачлалын виз авах шалгуур хангахгүй байх бүх үндэслэл өргөдөл гаргагчдад хамаатай байх болно. Тус хуульд визийн шалгуур хангахгүй байгаа ямар нэгэн үндэслэлээс чөлөөлөх тусгай заалтууд байхгүй бөгөөд ийнхүү чөлөөлөгдөх хүсэлтийг тусгайлан авч үздэг журам байхгүй. АНУ-ын иргэн буюу Хууль ёсны байнгын оршин суугч гадаадын иргэний ойрын хамаатантай хүмүүст хамаатай хөнгөлөх заалт DV өргөдөл гаргагчид хамаатай байж болох боловч DV хөтөлбөрийн цаг хугацааны шахуу байдлаас хамаарч иймэрхүү заалт ач холбогдлоо өгөх нь бага байх магадлалтай.

DV ХӨТӨЛБӨРТӨЙ ХОЛБОГДОХ ХУУРАМЧ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ЛУЙВАР АЖИЛЛАГАА

35. ИНТЕРНЕТИЙН ЗАЛИЛАН БУЮУ ХҮСЭЭГҮЙ И-МЭЙЛИЙН ТАЛААР ХЭРХЭН МЭДЭЭЛЭХ ВЭ?

Холбооны худалдааны комиссын ажиллуулдаг, 17 улсын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагуудын хамтарсан www.econsumer.gov вэбсайт руу хандана уу. Холбооны мөрдөх товчооны (ХМТ) Интернетийн гэмт хэргийн талаар гомдол хүлээн авах төв буюу IC3-т Internet Crime Complaint Center –т хандаж болно. Хүсээгүй и-мэйлийн талаар гомдол гаргахын тулд Хууль зүйн департаментын вэбсайтынх “contact us” (бидэнд ханд) гэсэн нүүрээр дамжуулан хандана уу.

DV СТАТИСК

36. DV-2015 ХӨТӨЛБӨРТ ХЭДЭН ВИЗ ОЛГОГДОХ ВЭ?

Хуульд заасны дагуу АНУ-ын олон үндэстний цагаачлалын хөтөлбөрөөр шаардлага хангасан хүмүүст жил бүр дээд тал нь 55,000 байнгын оршин суугчийн виз олгох ёстой. Гэхдээ 1997 оны 11 сард Конгрессоос баталсан Никарагуагийн асуудлыг зохицуулах, Төв Америкт туслах хуулинд (NACARA) DV-1999-ээс эхлэн шаардлагатай хугацааны турш олон үндэстний визийн хөтөлбөрт жил бүр хуваарилдаг 55,000 визээс 5,000-ыг нь NACARA хөтөлбөрт олгохоор заасан. Олон үндэстний визийн хөтөлбөрт хуваарилдаг визний тоог 5,000-аар бууруулсан энэхүү шийдвэрийг DV-2000-аас эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд DV-2015 хөтөлбөрийн хугацаанд хэвээр мөрдөгдөх хандлагатай байна.

БУСАД

37. ХЭРВЭЭ БИ DV ХӨТӨЛБӨРӨӨР ДАМЖУУЛАН ВИЗ АВБАЛ АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР НАДАД ТЭНД БАЙР СУУРИА ОЛТОЛ ТЭНД ХҮРЭХ ОНГОЦНЫ БИЛЕТ, БАЙР СУУЦ, АЖЛЫН БАЙР ОЛЖ ӨГӨХ, ЭРҮҮЛ МЭНД БОЛОН МӨНГӨН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ҮҮ?

Үгүй. Та DV хөтөлбөрийн дагуу виз авахад АНУ-н засгийн газраас таньд дээрхи үйлчилгээний алиныг нь ч үзүүлэхгүй. Хэрвээ та DV хөтөлбөрт сонгогдож виз мэдүүлэх бол виз авахаасаа өмнө АНУ-д очоод АНУ-ын Засгийн Газраас ямар нэгэн тэтгэмж авахгүй гэдгээ батлан харуулан шаардлагатай. Үүнд таны хувийн эд хөрөнгө, АНУ-д оршин суудаг таны хамаатан эсвэл найз нөхдөөс таныг санхүүгийн хувьд дэмжинэ гэдгийг баталсан I-134 өргөдөл, эсвэл АНУ-д таныг ажилд авна гэсэн ажлын урилга зэрэг багтана.

УУГУУЛ ИРГЭД НЬ DV-2015 ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ ЭРХ БҮХИЙ УЛС ОРНЫ ЖАГСААЛТ (БҮС НУТГААР)

Доорхи жагсаалтад уугуул иргэд нь DV-2015 хөтөлбөрт оролцох эрхтэй улс орнуудыг тус хөтөлбөрт мөрддөг газарзүйн бүсээр хуваж жагсаалаа. Хараат нутаг дэвсгэрүүд өөрийн захирагддаг улс орнуудын бүс нутагт багтана.Уугуул иргэд нь DV-2015 хөтөлбөрт оролцох эрхгүй улс орнуудыг АНУ-ын Иргэншил, Цагаачлалын Алба (USCIS) Цагаачлал, харьяаллын тухай хуулийн 203(c) хэсэгт заасан томъёоллын дагуу тогтоодог. Энэхүү олон үндэстний хөтөлбөрт уугуул иргэд нь оролцох эрхгүй улс орнуудыг (гэр бүлийн болон хөдөлмөр эрхлэлтийн цагаачлалын гол эх сурвалж болсон улс орнууд, өөрөөр хэлбэл "АНУ руу цагаач их гарсан" улс орнууд) тухайн бүс нутгийн улс орны жагсаалтын дараа жич тэмдэглэсэн.

<u>АФРИК</u>

Алжир
Ангол
Бенин
Ботсвана
Буркино-Фасо
Бурунди
Камерун
Кабо-Верде
Төв Африкийн Бүгд Найрамдах Улс
Чад
Коморын арлууд
Конго
Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс
Кот д'Ивуар (Зааны ясан эрэг)
Джибути
Египет*
Экваторын Гвиней
Эритрей
Этиоп
Габон
Гамби
Гана
Гвиней
Гвиней-Биссау
Кени
Лесото
Либери
Ливи
Мадагаскар
Малави
Мали

Мавритани
Маврик
Марокко
Мозамбик
Намиби
Нигер
Нигери
Руанда
Сан Томе ба Принсипи
Сенегал
Сейшелийн арлууд
Сьерра-Леоне
Сомали
Өмнөд Африк
Өмнөд Судан
Судан
Свазиленд
Танзани
Того
Тунис
Уганда
Замби
Зимбабве

*1967 оны 6 дугаар сараас өмнө Израил, Иордан, Сир болон Египтийн захиргаанд байсан нутаг дэвсгэрт төрсөн хүмүүс Израил, Иордан, Сири болон Египт улсынхаа нэрээр хөтөлбөрт оролцоно. Газын зурваст төрсөн иргэд Египетийн нэрээр, West Bank буюу Баруун эрэгт төрсөн хүмүүс Иорданы нэрээр, Golan Heights (Голан Хаятс) –д төрсөн хүмүүс Сирийн нэрээр хөтөлбөрт оролцох боломжтой.

Африкт Нигерийн уугуул иргэд энэ жилийн олон үндэстний визний хөтөлбөрт **оролцох эрхгүй.**

<u>АЗИ</u>

Афганистан
Бахрейн
Бутан
Бруней
Бирм
Камбож
Хонгконгийн Тусгай захиргаатай бүс**
Индонез
Иран
Ирак
Израил*
Япон
Иордан*
Кувейт
Лаос
Ливан
Малайз
Мальдив
Монгол
Балба

Хойд Солонгос
Оман
Катар
Саудын Араб
Сингапур
Шри-Ланк
Сири*
Тайвань**
Тайланд
Тимор-Лэстэ
Арабын Нэгдсэн Эмират
Йемен

*1967 оны 6 дугаар сараас өмнө Израил, Иордан, Сир болон Египтийн захиргаанд байсан нутаг дэвсгэрт төрсөн хүмүүс Израил, Иордан, Сири болон Египт улсынхаа нэрээр хөтөлбөрт оролцоно. Газын зурваст төрсөн иргэд Египетийн нэрээр, West Bank буюу Баруун эрэгт төрсөн хүмүүс Иорданы нэрээр, Golan Heights (Голан Хаятс) –д төрсөн хүмүүс Сирийн нэрээр хөтөлбөрт оролцох боломжтой.

Доор дурдсан Азийн бүсийн улс орнуудын уугуул иргэд энэ жилийн олон үндэстний визний хөтөлбөрт **оролцох эрхгүй: Бангладеш, Хятад (эх газрын), Энэтхэг, Пакистан, Өмнөд Солонгос, Филиппин болон Вьетнам. Хонг Конгийн Тусгай захиргааны бүс (Азийн бүс нутаг), Макаогийн Тусгай захиргаатай бүс (Европын бүс нутаг) болон Тайванийн (Азийн бүс нутаг) уугуул иргэд өргөдөл гаргах эрхтэй бөгөөд дээрх жагсаалтанд багтсан.

<u>ЕВРОП</u>

Албани
Андорра
Армен
Австри
Азербайжан
Беларус
Бельги
Босни Герцеговин
Болгар
Хорват
Кипр
Бүгд Найрамдах Чех Улс
Дани (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Эстони
Финланд
Франц (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Гүрж
Герман
Грек
Унгар
Исланд
Ирланд
Итали
Казахстан
Косова
Киргизстан
Латви

Лихтенштейн
Литва
Люксембург
Макаогийн Тусгай захиргаатай бүс**
Македони
Мальта
Молдов
Монако
Монтенегро
Нидерланд (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Умард Ирланд**
Норвеги
Польш
Португал (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Румын
ОХУ
Сан Марино
Серби
Словак
Словен
Испани
Швед
Швейцар
Тажикстан
Турк
Туркменистан
Украйн
Узбекстан
Ватикан хот улс

Доор дурдсан Европын улс орнуудын уугуул иргэд энэ жилийн олон үндэстний хөтөлбөрт **оролцох эрхгүй: Их Британи, Их Британид (Нэгдсэн Вант Улс) дараах хараат нутаг дэвсгэр орно: Ангилья, Бермуд, Британийн Виржинийн арлууд, Кейманы арлууд, Фолклендийн арлууд, Гибралтар, Монтсеррат, Питкэрн, Сэнт Элен, Төркс ба Кэйкос арлууд. Зөвхөн олон үндэстний визний хөтөлбөрт хамруулах зорилгоор Умард Ирландыг тусад нь авч үздэг бөгөөд Умард Ирланд энэ хөтөлбөрт **оролцох эрхтэй** тул дээрх жагсаалтад орсон. Мөн Макаогийн Тусгай захиргаатай бүс оролцох эрхтэй бөгөөд дээрх жагсаалтанд багтсан.

ХОЙД АМЕРИК

Багамын арлууд

Хойд Америкийн тухайд Канад болон Мексикийн уугуул иргэд энэ жилийн олон үндэстний визний хөтөлбөрт оролцох эрхгүй.

НОМХОН ДАЛАЙН ОРНУУД

Австрали (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Фижи
Кирибати
Маршаллын арлууд
Микронезийн Холбооны Улсууд

Науру
Шинэ Зеланд (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Палау
Папуа Шинэ Гвиней
Соломон арлууд
Тонга
Тувалу
Вануату
Самоа

ӨМНӨД АМЕРИК, ТӨВ АМЕРИК БОЛОН КАРИБЫН ТЭНГИСИЙН УЛС ОРНУУД

Антигуа Барбуда
Аргентин
Барбадос
Белиз
Боливи
Чили
Коста Рика
Куба
Доминик
Гренад
Гуатемал
Гайана
Гондурас
Никарагуа
Панам
Парагвай
Сэнт Киттс ба Невис
Сэнт Люси
Сэнт Винсент ба Гренадиний арлууд
Суринам
Тринидад ба Тобаго
Уругвай
Венесуэл

Уугуул иргэд нь энэ жилийн олон үндэстний визний хөтөлбөрт **оролцох эрхгүй** улс орнууд:
Бразил, Колумби, Бүгд Найрамдах Доминикан Улс, Эквадор, Эль Сальвадор, Гаити, Ямайка, Мексик болон Перу.